



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/783

Ховд

Сум, багуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр /Ховд/-ийн ажилд  
дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а” дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Сум, багуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр /Ховд/-ийн 5 дугаар багц /Цэцэг сумын төвийн гэрэлтүүлэг, Цэцэг сумын Хажинга багт худаг гаргах, Цэцэг сумын Баян-Овоо багт тэжээл хадгалах байр барих/, 6 дугаар багц /Чандмань сумын Жаргалан багт мал угаалгын ванн гаргах/, 7 дугаар багц / Мөст сумын Эрүүл мэндийн төвийн засвар/, 8 дугаар багц /Үенч суманд худаг гаргах, Үенч сумын Ерөнхий боловсролын сургуульд иж бүрэн хөгжим аппаратур худалдан авах/, 9 дүгээр багц /Хөдөөгийн багийн эмч нарт мотоцикль худалдан авах/ тус тус багцын ажлууд худалдан авах ажиллагааны цахим системээр 2 удаа зарлагдаж аж ахуй нэгж ороогүй тул шууд гэрээ байгуулах шийдвэр ирсэнтэй холбогдуулан ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулах боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Ганзориг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Zah A783 Kh

02 3957

- С.Дорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
- Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
- Цэцэг сумын Засаг дарга
  - Чандмань сумын Засаг дарга
  - Үенч сумын Засаг дарга
  - Мөст сумын Эрүүл мэндийн дарга
- Нарийн бичгийн  
дарга: Л.Батгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Дээрх ажлуудын ажлын тоо хэмжээг стандартын дагуу төсвийн хүрээнд нягтлан шалгаж дүгнэлт гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН